

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/19/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

  
**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

ОТГОН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА С.ЭНХ-ОРГИЛ-д

№ 2022. Д.А № 1902/231  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгон сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бнш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012025328

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Д.БАТ-УНДРАА



Хүлээн авсан  
Огноо: 2022.02.24  
Хүннэм: 2  
Борлуулсан  
Хүннэм: 2  
Д.Бат-Ундраа

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,209,765.41</b>	<b>44,819,548.33</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	13,476,613.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	13,476,613.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	13,476,613.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	13,476,613.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	123,035.41	43,305.33
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	123,035.41	43,305.33
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	27,086,730.00	31,299,630.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,262,655.00	1,910,155.00
35110	Тусгай зориулалттай материал	1,262,655.00	1,910,155.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,824,075.00	29,389,475.00
35410	Бичиг хэргийн материал	825,800.00	1,021,000.00
35420	Аж ахуйн материал	4,454,975.00	4,165,975.00
35430	Сэлбэг хэрэгсэл	77,500.00	478,000.00
35440	Түлц, шатах тослох материал	1,983,000.00	1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,482,800.00	22,724,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>567,895,301.89</b>	<b>549,678,038.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	567,895,301.89	549,678,038.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	563,251,801.89	545,282,038.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	616,166,647.65	616,166,647.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(114,776,371.44)	(154,236,544.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,117,720.00	106,617,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,313,653.28)	(60,377,231.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,008,783.16	149,008,783.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(113,247,526.07)	(135,250,343.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,888,270.77	33,266,039.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,687,146.22)	(21,379,290.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,175,310.00	34,409,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(34,923,712.68)	(26,036,471.77)
39217	Ном	2,843,480.00	3,093,480.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,643,500.00	4,396,000.00
39301	Програм хангамж	2,237,000.00	2,237,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(779,500.00)	(1,027,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,186,000.00	3,186,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>595,105,067.30</b>	<b>594,497,587.09</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>595,105,067.30</b>	<b>594,497,587.09</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	595,105,067.30	594,497,587.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781,468,090.14	781,468,090.14
51101	Өмч: - төрийн	781,468,090.14	781,468,090.14
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(398,726,111.54)	(399,333,591.75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(398,726,111.54)	(398,726,111.54)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(607,480.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,363,088.70	212,363,088.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>595,105,067.30</b>	<b>594,497,587.09</b>

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>412,602,195.00</b>	<b>422,800,190.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,538,500.00</b>	<b>99,539,990.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,538,500.00</b>	<b>99,539,990.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,856,000.00	51,717,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,856,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	51,717,000.00
120009	Бусад орлого	1,682,500.00	47,822,990.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>398,063,695.00</b>	<b>323,260,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>395,293,700.00</b>	<b>323,260,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	395,293,700.00	323,260,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,769,995.00</b>	<b>-</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,769,995.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>386,038,913.16</b>	<b>423,407,670.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>386,038,913.16</b>	<b>423,407,670.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>368,407,413.16</b>	<b>423,299,276.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>228,366,702.00</b>	<b>226,270,100.00</b>
210101	Үндсэн цалин	228,366,702.00	209,642,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	16,627,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,476,841.75</b>	<b>30,626,330.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,411,170.19	21,575,330.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,283,667.14	2,262,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,826,932.71	1,810,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	450,462.43	452,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,504,609.28	4,525,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,118,300.00</b>	<b>24,921,113.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,060,300.00	3,400,113.00
210302	Түлш, халаалт	8,058,000.00	21,521,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,755,105.00</b>	<b>19,445,330.00</b>
210401	Бичиг хэрэг	2,153,700.00	3,550,340.00
210402	Тээвэр, шатахуун	6,555,005.00	12,689,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,548,400.00	2,916,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	498,000.00	289,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>1,881,600.00</b>
210502	Хоол, хүнс	-	1,881,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,195,400.00</b>	<b>1,253,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,195,400.00	-
210604	Урсгал засвар	-	1,253,100.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>4,052,000.00</b>	<b>4,061,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,052,000.00	4,061,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,012,487.00</b>	<b>15,176,943.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,924,758.00	14,230,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	289,205.00	454,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	80,410.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246,800.00	80,000.00
210807	Газрын төлбөр	91,924.00	44,103.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,430,577.41</b>	<b>99,663,760.13</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,212,700.00	31,065,037.00

Отгон сумын Засаг дарын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	131,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,914,477.41	68,467,263.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,631,500.00	108,394.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,631,500.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,631,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	108,394.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,394.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>26,563,281.84</b>	<b>(607,480.21)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>26,563,281.84</b>	<b>(607,480.21)</b>

### 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(381,635,738.72)	612,195,440.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(381,635,738.72)	612,195,440.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	26,563,281.84	26,563,281.84
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(398,726,111.54)	595,105,067.30
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(398,726,111.54)	595,105,067.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(398,726,111.54)	595,105,067.30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(607,480.21)	(607,480.21)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,468,090.14	212,363,088.70	(399,333,591.75)	594,497,587.09

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>412,602,195.00</b>	<b>371,083,190.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,538,500.00</b>	<b>47,822,990.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,538,500.00</b>	<b>47,822,990.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,856,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,856,000.00	-
120009	Бусад орлого	1,682,500.00	47,822,990.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>398,063,695.00</b>	<b>323,260,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>395,293,700.00</b>	<b>323,260,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	395,293,700.00	323,260,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,769,995.00</b>	<b>-</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	2,769,995.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>395,198,581.00</b>	<b>357,356,577.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>395,198,581.00</b>	<b>357,356,577.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>377,567,081.00</b>	<b>357,248,183.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>226,268,899.00</b>	<b>226,270,100.00</b>
210101	Үндсэн цалин	206,382,455.41	209,642,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,886,443.59	16,627,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,547,800.00</b>	<b>30,546,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,495,600.00	21,495,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,262,700.00	2,262,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,810,200.00	1,810,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	453,800.00	452,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,525,500.00	4,525,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,638,300.00</b>	<b>24,093,113.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,060,300.00	3,400,113.00
210302	Түлш, халаалт	16,578,000.00	20,693,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,249,195.00</b>	<b>19,092,490.00</b>
210401	Бичиг хэрэг	3,883,600.00	3,455,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,713,495.00	12,534,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,652,100.00	3,102,550.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,053,400.00</b>	<b>1,653,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,695,400.00	-
210604	Урсгал засвар	1,358,000.00	1,653,600.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>4,052,000.00</b>	<b>4,061,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,052,000.00	4,061,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>32,812,487.00</b>	<b>13,508,040.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,924,758.00	12,561,977.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	289,205.00	454,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	80,410.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,046,800.00	80,000.00
210807	Газрын төлбөр	91,924.00	44,103.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,945,000.00</b>	<b>38,023,240.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,641,600.00	37,784,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	239,000.00

Отгон сумын Засаг дарын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,631,500.00	108,394.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,631,500.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,631,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	108,394.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	108,394.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,403,614.00	13,726,613.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	250,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	250,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(250,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,403,614.00	13,476,613.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,293,614.00	13,476,613.00

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	323,260,200.00	323,151,806.00	108,394.00	100%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	323,260,200.00	323,151,806.00	108,394.00	100%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	323,260,200.00	323,151,806.00	108,394.00	100%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	226,270,100.00	226,270,100.00	-	100%
210101	Үндсэн цалин	209,642,900.00	209,642,900.00	-	100%
210105	Гэрээт ажлын хөлс	16,627,200.00	16,627,200.00	-	100%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,546,600.00	30,546,600.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	21,495,600.00	21,495,600.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,262,700.00	2,262,700.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,810,200.00	1,810,200.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	452,600.00	452,600.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,525,500.00	4,525,500.00	-	100%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,096,800.00	24,093,113.00	3,687.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,772,600.00	3,400,113.00	372,487.00	90%
210302	Түлш, халаалт	20,324,200.00	20,693,000.00	(368,800.00)	102%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,098,500.00	19,092,490.00	6,010.00	100%
210401	Бичиг хэрэг	3,455,000.00	3,455,000.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	12,554,800.00	12,534,940.00	19,860.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,088,700.00	3,102,550.00	(13,850.00)	100%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,653,600.00	1,653,600.00	-	100%
210604	Урсгал засвар	1,653,600.00	1,653,600.00	-	100%
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	4,065,300.00	4,061,000.00	4,300.00	100%
210702	Дотоод албан томиллолт	4,065,300.00	4,061,000.00	4,300.00	100%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,240,300.00	2,726,063.00	(485,763.00)	122%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,780,000.00	(580,000.00)	148%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	454,500.00	454,450.00	50.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,500.00	80,410.00	90.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	80,000.00	80,000.00	-	100%
210807	Газрын төлбөр	138,200.00	44,103.00	94,097.00	32%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,289,000.00	14,708,840.00	580,160.00	96%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,469,840.00	530,160.00	96%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	289,000.00	239,000.00	50,000.00	83%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	323,260,200.00	323,260,200.00	-	100%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	323,260,200.00	323,260,200.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	323,260,200.00	323,260,200.00	-	100%

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,346,377.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,346,377.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,346,377.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,561,977.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,561,977.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,784,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,784,400.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Отгон сумын ЗДТГ-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Отгон сумын ЗДТГ нь сумын Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөл бололцоогоор хангахын зэрэгцээ цаг үеэ олсон, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах замаар хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний акт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Отгон сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгж байхгүй.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Отгон сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал

сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 287,073.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,870.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,009.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 422.800,1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,222.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,959.6 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	123.0	43.3	-79.7
Бараа	27,086.7	31,299.6	4,212.9
Үндсэн хөрөнгө	567,895.3	549,678.0	-18,217.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>595,105.0</b>	<b>581,020.9</b>	<b>-14,084.1</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	595,105.0	581,020.9	-14,084.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>	<b>595,105.0</b>	<b>581,020.9</b>	<b>-14,084.1</b>

Авлага дансны үлдэгдэл 79.7 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбогдсон авлагыг бууруулсантай байна.

Бараа материалын данс 4,212.9 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалт тусгай зориулалтын материал, бараа хангамжийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 18,217.3 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд 35,888.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан болон хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,084.1 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 323,260.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 323,260.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 323,151.8 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 13,585.0 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 34,346.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 11,561.98 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 22,784.4 мянган төгрөгийг тус тус бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 148 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, жолоочийн тооцоог сар бүр бодох хэвших, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 21,400.0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн, 11,600.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын үед залруулж, 9,800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлжээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3,950.0 мянган төгрөг, нэхэмжлэлийн дагуу тайлагнаагүй түлшний зардал 7,085.5 мянган төгрөг, Үр дүнгийн тайлангийн зөрүү 564.5 нийт 11,600.0 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийсэн.

### **4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.**

### **4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.**

### **4.4 Зөвлөмж:**

#### **1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

- ✓ **Илрүүлэлт:** 9,800.0 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодож, эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
- ✓ **Өгсөн зөвлөмж:** Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулах, материалын тайланг хугацаанд нь гаргуулан, тооцоо бодож хэвших

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Отгон сумын ЗДТГ	4	21.4	3	11.6	-	-	-	-	1	9.8